



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Ахмадын хорооны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/09/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Дархан-Уул аймаг
2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: **С.Батцэцэг**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Дундманхайдай аудит”

ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Утас: 91991462

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН АХМАДЫН
ХОРООНЫ ДАРГА Д.ЦЭРЭНДАВАА
ТАНАА

2022.02.25 № 139
танай -ны № -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Ахмадын хорооны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Ахмадын хорооны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.МӨНХБАЯР



009020247

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	<u>21,264,531.26</u>	<u>18,916,166.91</u>
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	<u>745,094,308.76</u>	<u>828,676,796.87</u>
	Нийт хөрөнгийн дүн	<u>766,358,840.02</u>	<u>847,592,963.78</u>
	Нийт өр төлбөрийн дүн	<u>241,000.00</u>	<u>00.00</u>
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн		
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн		
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	255,223,940.42	280,900,966.00
	Үйл ажиллагааны зардлын дүн	229,588,814.30	304,465,167.24
	Үйл ажиллагааны үр дүн	<u>25,635,126.12</u>	<u>-23,564,201.24</u>
	Үйл ажиллагааны бус үр дүн	-392,084.43	00.00
	Үйл ажиллагааны нийт үр дүн	<u>25,243,041.69</u>	<u>-23,564,201.24</u>
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	740,874,798.33	766,117,840.02
	Тайлант оны үр дүн	50,853,201.69	-23,564,201.24
	Эцсийн үлдэгдэл	766,117,840.02	847,592,963.78
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	<u>229,613,780.42</u>	<u>236,980,080.00</u>
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	<u>209,600,813.14</u>	<u>231,453,979.55</u>
	Үйл ажиллагааны ЦМГ	<u>20,012,967.28</u>	<u>5,526,100.45</u>
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	<u>-6,337,923.94</u>	<u>-3,816,000.00</u>
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	13,675,043.34	1,710,100.45
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	188,283,700.00	201,712,695.00
	Урсгал зардал	188,283,700.00	201,712,695.00
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	188,283,700.00	196,675,700.00
	Орон нутгийн төсвөөс		
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	00.00	196,675,700.00

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улс орныхоо хөгжил, дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулсан ахмадуудаа хүндэтгэх, залуу хойч үеийг тэдний хөдөлмөрч уламжлалаар хүмүүжүүлэх, ахмад настанд тавих анхаарал халамжийг дээшлүүлэх зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж болон орон тоо байхгүй.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Дархан-Уул аймгийн Ахмадын хорооны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд ашиглаж байгаа боловч үлдэх өртөггүй 9,439.5 мянган төгрөгийн 38 нэр төрлийн хөрөнгө болон улсын бүртгэлийн гэрчилгээнд 721,353.7 мянган төгрөгөөр дүрмийн санг нэмэгдүүлж холбогдох байгууллагуудад хүсэлт гаргаж шийдвэрлүүлсэн байдалд дараагийн аудитаар хяналтыг хэрэгжүүлнэ.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 678.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 250.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 428.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

1. Кассаас бэлэн мөнгө олгосон цахилгаан шугамын гэмтэл зассан 250.000.00 төгрөг нь анхан шатны баримтгүй хүлээн авсан хүний гарын үсгийн баталгаажилтгүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн ба "Оршин байх", "Үнэн зөв байх", "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Кассаас бэлэн мөнгө олгосон жагсаалтаар 2,051,418.00 төгрөгөөс 428,850.00 төгрөг нь хүлээн авсан хүний гарын үсгийн баталгаажилтгүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэнтэй нийцэхгүй, “Үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	2	678.8	-	-	1	250.0	-	-	1	428.8
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	2	678.8	-	-	1	250.0	-	-	1	428.8



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25

Дугаар 12/15510526/1111-2222/10/14-СА-ОНА Дархан сум

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дархан-Уул аймгийн Ахмадын хорооны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Кассаас бэлэн мөнгө олгосон цахилгаан шугамын гэмтэл зассан 250.000.00 /Хоёр зуун тавин мянган төгрөг/ төгрөг нь анхан шатны баримтгүй хүлээн авсан хүний гарын үсгийн баталгаажилтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйцэтгэл гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; гэсэн тус тус заалт, "Тасалбар болголт" батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.3.6-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Кассаас бэлэн мөнгө олгосон цахилгаан шугамын гэмтэл зассан 250.000.00 төгрөг нь анхан шатны баримтгүй хүлээн авсан хүний гарын үсгийн баталгаажилтгүй зарцуулсан зөрчлийг Нягтлан бодогч Д.Оюунчимэгээр төлүүлж, Төрийн сан банкин дахь Даа.Хүү, торгуулийн орлогын 100190000988 тоот дансанд төвлөрүүлэх,

2. Актын биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор төлүүлж Дархан - Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дархан-Уул аймгийн Ахмадын хорооны дарга Д.Цэрэндаваа, Нягтлан бодогч Д.Оюунчимэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР

Ж.БЯМБАЖАВ

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.МӨНХБАЯР

009050144

